

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГАА-2024/18-5-ШТА-ГА



Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа
Утас: 70483413
Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг
Утас: 70484055
Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn
Аудитор Ц.Сайханжаргал
Утас: 88665099
Цахим хаяг: Saikhanjargalts@audit.gov.mn

Тайлантай холбоотой мэдээллийг дээрх хаягаар холбогдож авна уу.
2024 он



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
БҮЛЭГ 1. ТАЙЛАНТ ОНД ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТЛААГҮЙ БАЙНА.	8
Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хэрэгжүүлж буй тул орон нутагт мэдээлэлгүй байна.	8
Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах талаар шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.	8
Орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.	13
БҮЛЭГ 2. ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.	13
Төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд зураг төсөв, техникийн шаардлагын дагуу комиссын дүгнэлтийн дагуу хүлээн авсан байна.	13
Төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа зохиогчийн болон техник хяналтын дүгнэлтийг үндэслэн ашиглалтад хүлээн авсан байна.	14
Тайлант онд хүлээн авсан 356.9 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.	14
БҮЛЭГ 3. ХҮЛЭЭН АВСАН ИХ ЗАСВАРЫН АЖЛУУД НЬ ЧАНАР БАЙДАЛ МУУТАЙ БАЙНА.	15
Төсөл, арга хэмжээ зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.	15
Төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.	19
БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.	21
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 55.0 хувь нь аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.	21
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.	21
Тайлант онд хүлээн авсан 3 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 25.8 сая төгрөгийн гүйцэтгэгчид олгоогүй байна.	25
Төсөл, арга хэмжээг хүлээн авч гэрээг дүгнэж байгаа боловч үр дүнг тодорхойлоогүй байна.	26
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР	28
САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР:	30
ДҮГНЭЛТ:	31
ШИЙДВЭР:	31



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГАА	Говь-Алтай аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/ зуухны барилга	8
Зураг 2	Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/ дэд бүтэц, шугам сүлжээ	8
Зураг 3	Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/ дулааны шугам	8
Зураг 4	Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /ГАА, Есөнбулаг сум/	8
Зураг 5	Цэцэрлэгийн барилга 100 ор /ГАА, Халиун сум/	9
Зураг 6	Цэцэрлэгийн барилга 75 ор /ГАА, Алтай сум/	9
Зураг 7	Жишиг гудамж тохижилт /ГАА, Есөнбулаг сум/	9
Зураг 8	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тонхил сум/	10
Зураг 9	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Цээл сум/	10
Зураг 10	Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	11
Зураг 11	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Хөхморьт сум/	12
Зураг 12	Дотуур байрны барилга /Говь-Алтай, Тайшир сум/	13
Зураг 13	"Цэвэрлэх байгууламжийн барилга" /Говь-Алтай, Халиун сум/ гадна тал	14
Зураг 14	"Цэвэрлэх байгууламжийн барилга" /Говь-Алтай, Халиун сум/ дотор тал	14
Зураг 15	"Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух"-ны шугам булсан байдал /Говь-Алтай, Цээл сум/.	14
Зураг 16	"Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух"-ны дэд бүтэц /Говь-Алтай, Цээл сум/.	14
Зураг 17	"Бохир усны шугам сүлжээ" /Говь-Алтай, Халиун сум/	15
Зураг 18	"Алтай" чуулгын хуучин барилгыг "Багшийн хөгжлийн ордон" болгож өөрчлөх /Говь-Алтай, Есөнбулаг сум/ гадна тал	15
Зураг 19	"Алтай" чуулгын хуучин барилгыг "Багшийн хөгжлийн ордон" болгож өөрчлөх /Говь-Алтай, Есөнбулаг сум/ дотор тал	15
Зураг 20	"Сургуулийн спорт заалны барилга" /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2 дугаар сургууль/ гадна	16
Зураг 21	"Сургуулийн спорт заалны барилга" /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2 дугаар сургууль/ дотор тал	16
Зураг 22	"Сургуулийн спорт заалны барилга" /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар сургууль/ гадна тал	16
Зураг 23	"Сургуулийн спорт заалны барилга" /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар сургууль/ дотор тал	16
Зураг 24	"Сургуулийн спорт заалны барилга" /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/ гадна тал	16
Зураг 25	"Сургуулийн спорт заалны барилга" /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/ дотор тал	16
Зураг 26	Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар цэцэрлэг/ гадна тал	17
Зураг 27	Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар цэцэрлэг/ таазны бэхэлгээ	17



Зураг 28	Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 8 дугаар цэцэрлэг/ гадна тал	17
Зураг 29	Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 8 дугаар цэцэрлэг/ дотор тал	17
Зураг 30	Сургуулийн барилгын их засвар /Говь-Алтай, Төгрөг сум/	18
Зураг 31	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Дэлгэр сум/ гадна тал	18
Зураг 32	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Дэлгэр сум/ дотор тал	18

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг	21
Хүснэгт 2	Төсөл, арга хэмжээний ангилал	21
Хүснэгт 3	Аймгийн ИТХ-аар тодотгол хийгдсэн байдал	22
Хүснэгт 4	Худалдан авах ажиллагаа	24
Хүснэгт 5	Төсөл, арга хэмжээний санхүүжилт	25



АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/152 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилго	“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх; - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх; - Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх; - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ, түүний харьяа байгууллагууд болон сумдын ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газруудыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитын хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, Нийцлийн аудитын зарчим MNS 6817-7:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын шалгуур үзүүлэлт	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт



Аудитын баг, бүрэлдэхүүн	• Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль • Төсвийн тухай хууль • Төрийн хэмнэлтийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль • Барилгын тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Шилэн дансны тухай хууль • Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” • Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ц.Сайханжаргал, аудиторовн үүргийг орлон гүйцэтгэгч О.Энхтөр нар нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.
-----------------------------	---



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурал 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг баталжээ.

Говь-Алтай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,113.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий өмнөх онд эрх шилжүүлэн үргэлжлэн хэрэгжиж буй 12 төсөл, арга хэмжээг 2,536.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Төсөл арга хэмжээний 58.3 хувийг барилга байгууламж, 41.6 хувийг их засвар эзэлж байна. Эрх шилжиж ирсэн ажлаас 11 төсөл, арга хэмжээг хүлээж авсан 1 төсөл арга хэмжээ нь хэрэгжиж байна.

Тайлант онд шинээр хөрөнгө оруулалтын ажил батлагдаагүй бөгөөд ТЭЗҮ, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 20 төсөл, арга хэмжээг 325.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж 11 төсөл, арга хэмжээг 203.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Үүнээс 7 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн хүлээн авсан байна.

Шилэн данс: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл¹, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд эрх шилжин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 9,113.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээг олон нийтэд зохих цэсэд байршуулан мэдээлээгүй байна.

Удирдлагын систем: Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгохоор арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Аудитаар Говь-Алтай аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг тус цахим системд мэдээлсэн байна.

¹ 6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвөө, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргаасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.



БҮЛЭГ 1. ТАЙЛАНТ ОНД ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТЛААГҮЙ БАЙНА.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл²-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хэрэгжүүлж буй тул орон нутагт мэдээлэлгүй байна.

- 1.1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээнээс 16 нь орон нутагт эрх шилжсэн байна. Үүнээс 2022 онд 7 төсөл, арга хэмжээг хүлээн авч 9 төсөл, арга хэмжээ нь 2023 онд үргэлжлэн хэрэгжихээр тусгагдсан байна.
- 1.2. Гэвч Биеийн тамир, спортын улсын хорооноос 2022 онд Бигэр, Бугат, Есөнбулаг, Цогт сумын Баянтоорой тосгон, Тонхил сумын спорт заалны барилгын ажлын гэрээний хугацаа болон санхүүжилтэд өөрчлөлт оруулан, нэмэлт гэрээг байгуулсан байна.
- 1.3. Харин өмнөх оноос тайлант хугацаанд дамжин хэрэгжсэн “Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/” төсөл, арга хэмжээ нь ажлын даалгавар, зураг төсөв хуульд тусгагдсаны дараа буюу 2022 онд боловсруулагдсан, “Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/” төсөл, арга хэмжээ нь техникийн нөхцөл бүрэн олгогдоогүй байхад Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдсан байсныг “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан болно.

Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах талаар шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

- 1.4. Дээрх он дамжин хэрэгжихээр тусгагдсан 9 төсөл, арга хэмжээнээс 980.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/”, 359.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/” Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй байна. Уг 2 төсөл, арга хэмжээг Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргаас 2023 онд буцаан орон нутагт эрхийг шилжүүлжээ.
- 1.5. Харин аудитаар өмнөх онуудын хуульд тусгагдан хэрэгжиж байгаад дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээний судалгааг гаргахад дараах байдалтай байна. Үүнд:
 - 1.5.1. Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/ төсөл, арга хэмжээ нь анх Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XV.1.58-д 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр тусгагдаж Мандал голомт ХХК-тай гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон боловч хэрэгжиж дуусаагүй байна.
Гүйцэтгэгч зуухны барилга, гадна дулааны шугам сүлжээ, гадна холбооны шугам сүлжээний ажлыг гүйцэтгэн хэсэгчлэн комисс ажиллан, ашиглалтад оруулсан. Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил 70.0 хувийн

² Төсвийн тухай хуулийн 28.3-т “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно”
ГАА-2024/18-5-ШТА-ГА

гүйцэтгэлтэй, 2023 онд ажил гүйцэтгэх гэрээг дахин сунгасан ч ажил хийгдээгүй.

Захиалагч байгууллагаас гэрээг цуцалж шүүхэд хандаж шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг 2023 оны 12 дугаар сарын 05-ны 759 дугаар албан бичгээр гүйцэтгэгчид хүргүүлсэн байна.



/зураг №1/



/зураг №2/



/зураг №3/

- 1.5.2. Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээ нь анх Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIX.1.1.24-д тусгасан Ус-Алтай ХХК-тай гэрээ байгуулсан боловч ажлаа хугацаандаа гүйцэтгээгүй.

Гүйцэтгэгчид 176.0 сая төгрөгийн санхүүжилт олгож зөвхөн усан оргилуурын суурь цутгах ажлыг хийсэн байна.

Захиалагч талаас хуулийн байгууллагад нэхэмжлэл гарган ГААСДИХАШШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 133/ШШ2018/00567 дугаартай шийдвэрээр дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 371 дугаартай албан бичгээр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.



/зураг №4/

- 1.5.3. Цэцэрлэгийн барилга 100 ор /ГАА, Халиун сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIII.1.1.216-д тусгагдан Баянмогод ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 666.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа гүйцэтгээгүй тул Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 2/4250 дугаартай албан бичгээр гэрээг цуцалж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар хүлээгдэж байна.

Захиалагч талаас гүйцэтгэсэн ажилд хөндлөнгийн дүгнэлт гаргуулахаар Барилгын хөгжлийн төвд 2 удаа албан бичиг хүргүүлсэн.



/зураг №5/

- 1.5.4. Цэцэрлэгийн барилга 75 ор /ГАА, Алтай сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.1.1.350-д тусгаж, Си би Ай аутсорс ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 420.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Барилгын хөгжлийн төвийн дүгнэлтэд 2019 онд гүйцэтгэсэн барилгын суурийн ажлыг шаардлага хангаагүй тул буулгаж дахин суурийн ажлыг гүйцэтгүүлэхээр тусгасан.

Захиалагчаас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 354 дугаар, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 461 дүгээр, 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 534 дугаар албан шаардлагуудыг тус тус хүргүүлсэн боловч барилга угсралтын ажлыг эхлээгүй байна. Иймд 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1/1805 дугаартай албан бичгээр гэрээг цуцалж, хуулийн байгууллагад шилжүүлж, гүйцэтгэсэн ажилд дахин магадлал хийлгүүлж, тендер зарлахаар шийдвэрлэсэн.



/зураг №6/

- 1.5.5. Жишиг гудамж тохижилт /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XI.1.57-д тусгаж, гүйцэтгэгч 2020 онд хэрэгжүүлэн 2021, 2022 онд ажлыг хүлээлгэн өгөхөөр аймгийн ЗДТГ-т хандсан боловч чанар байдал муутай гэх шалтгаанаар захиалагч талаас хүлээж аваагүй байна.

Аудитаар чанар байдал муутай, бетонон замын зарим хэсэгт хайрга ил гарсан байна.



/зураг №7/

- 1.5.6. Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тонхил сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.2.1.53-д тусгаж Уран-Охид ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон.

Гүйцэтгэгчид 860.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд газар шороо, суурийн ажил, 1 дүгээр давхрын багана, дам нурууны арматурчлал, халаалтын тогооны барилгын газар шороо, суурийн ажил, өрлөгийн ажлыг гүйцэтгэсэн байна.

Захиалагч байгууллагаас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 354 дүгээр, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 463 дугаар албан шаардлагуудыг тус тус хүргүүлсэн.

Соёлын яамнаас 2023 онд гэрээ цуцалж, хуулийн байгууллагад шилжүүлсэн. Зураг төсөвт магадлал хийлгүүлж, дахин тендер зарлахаар шийдвэрлэсэн гэх тайлбарыг захиалагчаас ирүүлсэн байна.



/зураг №8/

- 1.5.7. Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.2.1.54-д тусгаж Уран-Охид ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон.

Гүйцэтгэгчид 765.5 сая төгрөгийн санхүүжилт олгож газар шороо, суурийн ажил, 1 дүгээр давхрын баганын арматурчлал, халаалтын тогооны барилгын суурийн ажил, 2 дугаар давхрын арматурчлалын ажлыг хийсэн байна. Зарим баганын хэв хашмалыг буулгаж, дахин хийсэн байна.

Захиалагчаас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 354 дүгээр, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 463 дугаар албан шаардлагуудыг тус тус хүргүүлсэн. Соёлын яамнаас гэрээг цуцалж, хуулийн байгууллагад шилжүүлсэн. Зураг төсөвт магадлал хийлгүүлж, дахин тендер зарлахаар шийдвэрлэсэн гэх тайлбарыг захиалагчаас ирүүлсэн байна.



/зураг №9/

1.5.8. Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.3.1.17-д тусгаж Мөнхөдбаярт хөхий ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон.

Гүйцэтгэгчид 175.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд 2020 онд газар шороо, суурийн ажил, 2021 онд метал карказыг угсарсан байна.

Биеийн тамир спортын улсын хорооноос 2022 онд Сонгомол хаус констракшн ХХК-тай гэрээ байгуулсан.

Захиалагч байгууллагаас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 354 дугаар, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 457 дугаар, 2022 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 561 дүгээр албан шаардлагуудыг тус тус хүргүүлсэн боловч барилга угсралтын ажлыг эхлээгүй байна.

Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тул захиалагчаас гэрээ цуцалсан. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/13 дугаар захирамжаар гүйцэтгэгч сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиглэлийг аймгийн ЗДТГ-т ирүүлсэн. Худалдан авах ажиллагааг 2 удаа зохион байгуулсан боловч гүйцэтгэгч шалгараагүй.

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/679 дугаар захирамжаар гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт олгосон. Тус газраас зарласан сонгон шалгаруулалтад 1 хуулийн этгээд үнийн санал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй гэх үндэслэлээр татгалзсан. Одоогоор оролцогч шалгараагүй байна.



/зураг №10/

1.5.9. Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Хөхморьт сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIII.1.2.10-д тусган “Аранжин-Алтай” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 153.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Захиалагч талаас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 355 дугаар, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 465 дугаар, 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 739 дугаар, 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 822 дугаар албан бичгээр шаардлага хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/334 дугаар захирамжаар томилсон ажлын хэсэг ажиллаж байна.



/зураг №11/

1.5.10. Дотуур байрны барилга /Говь-Алтай, Тайшир сум/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Чингисийн дуулга констракшн ХХК-тай 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ хийсэн боловч ажлыг эхлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-аас 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 2/1073 албан бичгээр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ цуцалсан.

Гүйцэтгэгчээс төсөвт өртөг хүрэлцэхгүй шалтгаанаар өөрийн хөрөнгөөр ажлын зураг төсвийг хийлгэж, магадлалын дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасныг 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч нар хуралдан хүсэлтийг хүлээн авсан байна.



/зураг №12/

Орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

1.6. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдан орон нутагт эрх шилжүүлсэн 12 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчидтэй байгуулсан гэрээнд санхүүжилтийг 3 үе шатаар буюу 30, 40, 30 хувиар олгохоор тусган гүйцэтгэлд үндэслэн 2,536.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

БҮЛЭГ 2. ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.

Төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд зураг төсөв, техникийн шаардлагын дагуу комиссын дүгнэлтийн дагуу хүлээн авсан байна.

2.1. Тайлант онд хэрэгжүүлсэн 12 төсөл, арга хэмжээний хувьд 5 нь 2020 оноос, 4 нь 2021 оноос, 3 нь 2022 оноос хэрэгжиж эхэлсэн байна.



- 2.2. Дээрх төсөл, арга хэмжээнээс 2021 онд³ 4, 2022 онд⁴ 4, 2023 онд⁵ 3, нийт 11-ийг зохих журмын дагуу хүлээн авчээ.

Төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа зохиогчийн болон техник хяналтын дүгнэлтийг үндэслэн ашиглалтад хүлээн авсан байна.

- 2.3. Тайлант хугацаанд хамаарах 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад захиалагчийг төлөөлж аймгийн ЗДТГ-тай байгуулсан гэрээний дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас техник хяналтыг хэрэгжүүлсэн байна. Мөн төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа зохиогчийн болон техник хяналтын дүгнэлтийг үндэслэсэн байна.
- 2.4. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний чанар байдал муутай, зарим талаар ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь зохиогчийн болон үе шатны хяналт хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой байна
- 2.5. Түүнчлэн өмнөх оны аудитаар чанар байдал муутай барилга байгууламж, их засварын ажлуудыг гүйцэтгэгчээр дахин засварлуулахаар өгсөн албан шаардлагыг албан тушаалтан солигдсон, ажлын хариуцлага, хяналт хангалтгүйгээс шалтгаалан бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд хүлээн авсан 356.9 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.

- 2.6. Хүлээн авсан 7,507.4 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнээс 10 төсөл, арга хэмжээний 7,150.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.
- 2.7. Харин улсын комиссын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн ГАА-КД-20/2023 дугаартай актаар хүлээн авсан 356.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/" төсөл, арга хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.5-д⁶ заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэр гаргаагүй гэх үндэслэлээр данс бүртгэлд тусгаагүй байна.

³ -"Алтай" чуулгын хуучин барилгыг "Багш хөгжлийн ордон" болгож өөрчлөх /Говь-Алтай, Есөнбулаг сум/
-Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 8 дугаар цэцэрлэг/
-Сургуулийн барилгын их засвар /Говь-Алтай, Төгрөг сум/
-Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Дэлгэр сум/

⁴ -Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2 дугаар сургууль/
-Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар сургууль/
-Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/
-Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар цэцэрлэг/

⁵ -Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/
-Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/
-Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/

⁶ Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

ГАА-2024/18-5-ШТА-ГА

БҮЛЭГ 3. ХҮЛЭЭН АВСАН ИХ ЗАСВАРЫН АЖЛУУД НЬ ЧАНАР БАЙДАЛ МУУТАЙ БАЙНА.

Төсөл, арга хэмжээ зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.

3.1. Тайлант онд хүлээн авсан 11 төсөл, арга хэмжээний ашиглалтыг аудитын явцад хянаж үзэхэд дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

- 3.1.1. “Цэвэрлэх байгууламжийн барилга” /Говь-Алтай, Халиун сум/
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн ГАА-КД-25/2023 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авсан байна.
Цэвэр усны шугам, цахилгаан хангамж хийгдээгүй байгаа тул ашиглаж эхлээгүй байна.



/зураг №13/



/зураг №14/

- 3.1.2. “Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух” /Говь-Алтай, Цээл сум/.
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн ГАА-КД-20/2023 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авсан боловч ашиглаж эхлээгүй байна.
Тус байршилд баригдах цэцэрлэгийн барилга нь баригдсан боловч Соёлын төвийн барилгын ажил эхлээгүй нь зориулалтын дагуу ашиглах боломжгүй байдлыг бий болгосон байна.



/зураг №15/



/зураг №16/

3.1.3. “Бохир усны шугам сүлжээ” /Говь-Алтай, Халиун сум/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн ГАА-КД-15/2023 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авсан.

Цэвэр усны шугам, цахилгаан хангамж хийгдээгүй байгаа тул ашиглаж эхлээгүй байна.



/зураг №17/

3.1.4. "Алтай" чуулгын хуучин барилгыг "Багшийн хөгжлийн ордон" болгож өөрчлөх /Говь-Алтай, Есөнбулаг сум/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ГАА-КД-32/2022 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага болох аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн.

Гэвч Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгыг нураан шинээр барьж байгаагаар холбогдуулан тус цэцэрлэг уг байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд барилгыг анх төлөвлөсний дагуу “Багш хөгжлийн ордон”-ы зориулалтаар ашиглаагүй байна.



/зураг №18/



/зураг №19/

3.1.5. “Сургуулийн спорт заалны барилга” /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2 дугаар сургууль/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн ГАА-КД-14/2022 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага болох Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд тусгасан.

Тус байгууллага нь спорт заалыг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Харин өвлийн улиралд ариун цэврийн өрөөний бохирын шугам хөлддөг гэх шалтгаанаар тус өрөөг ашиглахгүй байна.



/зураг №20/



/зураг №21/


3.1.6. “Сургуулийн спорт заалны барилга” /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар сургууль/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ГАА-КД-35/2022 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага болох Есөнбулаг сумын 3 дугаар сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд тусгасан.

Тус байгууллага нь спорт заалыг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Харин дотор суурилуулсан хяналтын камер ажилладаггүй, усны хаялага хэсэг газарт салхинд унасан бөгөөд ашиглагч байгууллагаас цас хайлах, бороо орох үед дээврээс ус гоождог гэх тайлбарыг өгсөн.



/зураг №22/



/зураг №23/

3.1.7. “Сургуулийн спорт заалны барилга” /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн ГАА-КД-32/2022 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага болох Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд тусгасан.

Тус байгууллага нь спорт заалыг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Харин ариун цэврийн өрөөний цэвэр усны шугам өвлийн улиралд хөлдсөн, агааржуулалтын систем бүрэн ажиллахгүй байна.



/зураг №24/



/зураг №25/

3.1.8. Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар цэцэрлэг/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ГАА-КД-26/2021 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага болох Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Тус барилгыг техникийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 08-07-033/07/13 дугаартай дүгнэлтээр ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан байхад 277.3 сая төгрөгийн их засварыг хийж хүлээлгэн өгсөн. Барилгын дээврийн хэсэгт нуралт үүссэн, цаашид ашиглахад эрсдэлтэй байна.



/зураг №26/



/зураг №27/

3.1.9. Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 8 дугаар цэцэрлэг/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн ГАА-КД-28/2021 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага болох Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Барилгыг зориулалтын дагуу ашиглаж байна.



/зураг №28



/зураг №29/

3.1.10. Сургуулийн барилгын их засвар /Говь-Алтай, Төгрөг сум/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ГАА-КД-38/2021 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага Төгрөг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Барилгын гадна өнгөлгөөнүүд хуурсан, дээврийн борооны хаялага бүрэн ажиллахгүй, анги танхимын шалны будаг ховхорсон байдалтай байна.



/зураг №30

3.1.11. Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Дэлгэр сум/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн ГАА-КД-29/2021 дугаар дүгнэлтээр баталгаажин төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглагч байгууллага Дэлгэр сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн, зориулалтын дагуу ашиглаж байна.



/зураг №31/



/зураг №32/

- 3.2. Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд барилга, байгууламжийг цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлэхгүй байгаагаас шалтгаалан ашиглалт хангалтгүй, хяналтыг үр нөлөөгүй хэрэгжүүлснээс чанар байдал муутай байна.

Төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

- 3.3. Тайлант онд хэрэгжүүлсэн 12 төсөл арга хэмжээнээс хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан эсэхийг авч үзэхэд “Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /” төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн нь шинэ технологи бүхий дулааны нэгдсэн системийг бий болгох Монгол Улсын урт⁷ болон аймгийн дунд⁸ хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцэхгүй, тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагаа болж чадаагүй байна.⁹

⁷ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9.3.3-т “Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлсэн байна”.

⁸ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтын 8.1.2.Сумдын төвийг төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системтэй болгоно.

⁹ “Улс, орон нутгийн төвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаас тусгав.
ГАА-2024/18-5-ШТА-ГА



- 3.4. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Говь-Алтай аймагт хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.
- 3.5. Түүнчлэн барилга байгууламжийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэхгүйгээс иргэд, олон нийтэд үзүүлэх ач холбогдол, үр өгөөж буурч байна.

Тухайлбал: Сумын төвийн шинэчлэл /Говь-Алтай, Дэлгэр сум/, Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг 2014-2015 онд, Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг анх 2020-2021 онд хэрэгжүүлэхээр баталсан боловч өнөөдрийг хүртэл ашиглалтад ороогүй байна.¹⁰

¹⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210334&showType=1>
ГAA-2024/18-5-ШТА-ГА



БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 55.0 хувь нь аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

- 4.1.1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”, 11 дүгээр тогтоолын хавсралтаар “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 58 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна.
- 4.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 20 төсөл, арга хэмжээг 1213.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс 15 нь өмнөх оноос шилжин хэрэгжихээр 5 нь шинээр хэрэгжихээр тусгагдсан байна.
- 4.1.3. Тус төсөл, арга хэмжээнээс 199.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ нь “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 859.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээ нь “аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-тэй нийцээгүй байна.


Хүснэгт 1. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг

д/д	Бодлогын баримт бичиг	Нийцсэн		Нийцээгүй	
		тоо	хувь	тоо	хувь
1	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	20	100	0	0
2	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	16	80	4	20
3	Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө	9	45	11	55

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

- 4.2.1. Батлагдсан төсөл, арга хэмжээг ангиллаар авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №2. Төсөл, арга хэмжээний ангилал.



Хүснэгтээс авч үзэхэд батлагдсан 20 төсөл, арга хэмжээнээс 20 хувийг хөрөнгө оруулалтын бус шинж чанартай урсгал зардалд төлөвлөжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹¹ дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- Галдан Бошгот хааны онгоны тахилгын арга хэмжээний бэлтгэл хангах зардал /100.0 сая төгрөг/
- Өрх бүрд өсөлт, иргэн бүрд орлого арга хэмжээний хүрээнд шинээр гэр бүл болж байгаа малчин залуу өрхийг малжуулах /200.0 сая төгрөг/
- Засагт хан аймаг, Хантайшир уулын аймаг болон Говь-Алтай аймгийн түүхтэй холбоотой судалгааны ажил /19.0 сая төгрөг/
- Сумдын 120 айлын орон сууцны зохиогчийн хяналтын зардал /15.0 сая төгрөг/

4.2.2. Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар 415.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, 5 удаа тодотгол хийсэн байна.

Хүснэгт №3. Аймгийн ИТХ-ын тогтоолд тодотгол хийгдсэн байдал

Д/д	Аймгийн ИТХ-ын тогтоол					Тайлбар
	Огноо	Дугаар	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
1	2023.03.24	14	18	940.7	557.9	11 төсөл, арга хэмжээ шинээр нэмэгдсэн, 17 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан.
2	2023.05.29	21	20	1,213.3	587.9	1 төсөл арга хэмжээг шинээр нэмж, 19 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан.
3	2023.06.30	23	20	1,213.3	325.6	16 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан.
4	2023.09.25	41	20	1,213.3	325.6	16 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан
5	2023.12.01	64	20	1,213.3	325.6	16 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан

4.2.3. Тодотголоор 75.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээг задлан 2 болгож, 838.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээг шинээр нэмсэн нь анх батлахдаа төлөвлөлтийг оновчтой хийгээгүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн тодотголоор 2 салгасан арга хэмжээ:

- Дулааны станц ДДТ-ын барилгын гадна холбоо дохиоллын шугам сүлжээний зураг төсөл /75.0 сая төгрөг/

Төсвийн тодотголоор шинээр нэмсэн төсөл арга хэмжээ:

- Засагт хан аймаг, Хантайшир уулын аймаг болон Говь-Алтай аймгийн түүхтэй холбоотой судалгааны ажил
- Бигэр сумын хорооллын гадна цахилгааны дэд өртөө, шугам сүлжээний ажил

¹¹ 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;
ГАА-2024/18-5-ШТА-ГА



- Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын зураг төсөл боловсруулах /Говь-Алтай, Есөнбулаг сум, Жаргалант баг
- Хөхморьт, Чандмань сумын инженерийн шугам сүлжээнд холбох ажлын зураг төсөл /УХАТ,ЦДАШ, Холбоо дохиолол, ДДТ-ийн барилга, 5 хос шугам
- Бигэр сумын нутаг дэвсгэрт баригдах 120 айлын орон сууцны өөрчлөлт, холболтын зураг
- Залуус цэцэрлэгт хүрээлэн, залуус гудамжны усалгааны систем
- Инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн цооног гаргах
- Өрх бүрд өсөлт, иргэн бүрд орлого арга хэмжээний хүрээнд шинээр гэр бүл болж байгаа малчин залуу өрхийг малжуулах /50 бог мал/
- Шарга сумын "Хамтын хүч" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх
- Алтай сумын "Баянцагаан" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх
- Сумдын 120 айлын орон сууцны зохиогчийн хяналтын зардал
- Есөнбулаг сумд байрлах Нийтийн номын сангийн зүүн уулзвараас, Солонго хорооллын уулзвар хүртэлх 300м автозамын ажил

4.2.4. Хэрэгжүүлэхээр батлагдсан 20 төсөл, арга хэмжээнээс 8-ийг 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр тусгажээ.

Түүнээс 575.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаврыг хийгээгүй байхад аймгийн ИТХ-аар баталсан байна.

Харин Сумдын 120 айлын орон сууцны зохиогчийн хяналтын зардал /15.0 сая төгрөг/ төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар хийлгэх шаардлагагүй гэж үзлээ.

- Усны машин нийлүүлэх /Төгрөг сум/ /50.0 сая төгрөг/
- Жаргалан сумд цэцэрлэгт хүрээлэн байгуулах /3.1 сая төгрөг/
- Өрх бүрд өсөлт, иргэн бүрд орлого арга хэмжээний хүрээнд шинээр гэр бүл болж байгаа малчин залуу өрхийг малжуулах /50 бог мал/ /200.0 сая төгрөг/
- Шарга сумын "Хамтын хүч" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх /25.0 сая төгрөг/
- Алтай сумын "Баянцагаан" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх /25.0 сая төгрөг/
- Есөнбулаг сумд байрлах Нийтийн номын сангийн зүүн уулзвараас, Солонго хорооллын уулзвар хүртэлх 300м автозамын ажил /272.6 сая төгрөг/

4.2.5. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад заасан төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага, аргачлалыг мөрдөж ажиллахгүй байгаагаас шалтгаалж байна. Тухайлбал: Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.6-т "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг энэ журамд заасныг баримтлан гүйцэтгээгүй, шаардлагатай баримт бичгийн иж бүрдэл, материал, мэдээллийг албан бичгээр болон цахим системээр ирүүлээгүй тохиолдолд хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгахгүй байх үндэслэл болно" гэж заасан боловч хэрэгжүүлээгүй байгааг дээрх байдлаар дүгнэж болохоор байна.

4.2.6. Мөн хууль тогтоомжид заасны дагуу төсөл, арга хэмжээний үр ашиг, цаашид гарах урсгал зардлын тооцоог хийхгүй байгаагаас хөрөнгө оруулалтын үр өгөөж, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг тооцох боломжгүй шаардлагатай байсан эсэх нь тодорхойгүй байна.



4.2.7. Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахимаар баталсан гэх боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (хуучин хуулиар)-ийн 48 дугаар зүйлд заасан худалдан авах ажиллагааг төлөвлөх үйл ажиллагаа хэрэгжсэн эсэхийг тодорхойлох боломжгүй нөхцлийг бүрдүүлсэн байна.

4.2.8. Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулжээ.

4.2.9. Тайлант онд орон нутгийн төсвөөс 697.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 391.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 худалдан авах ажиллагаа зарлаж 432.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд тендер шалгаруулалтаас хэмнэлт үүсээгүй байна.

Хүснэгт № 4 Орон нутгийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Тайлант оны санхүүжилт	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын журам
1	Усны машин нийлүүлэх /Төгрөг сум/	50.0	50.0	50.0	Нээлттэй
2	Жаргалан сумд цэцэрлэгт хүрээлэн байгуулах	3.1	3.1	3.1	Шууд
3	Багш хөгжлийн ордны гадна цэвэр дулааны шугам сүлжээний угсралт /үлдэгдэл санхүүжилт/	107.0	43.45	107.0	63.3 сая төгрөг-харьцуулалт
4	Өрх бүрт өсөлт, иргэн бүрт орлого арга хэмжээний хүрээнд шинээр гэр бүл болж байгаа малчин залуу өрхийг малжуулах /50 бог мал/	200.0	200.0		Хэрэгжээгүй
5	Шарга сумын "Хамтын хүч" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх	25.0	25.0		Харьцуулалт
6	Алтай сумын "Баянцагаан" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх	25.0	25.0		Харьцуулалт
7	Сумдын 120 айлын орон сууцны зохиогчийн хяналтын зардал	15.0	15.0		Шууд
8	Есөнбулаг сумд байрлах Нийтийн номын сангийн зүүн уулзвараас, Солонго хорооллын уулзвар хүртэлх 300м автозамын ажил	272.6	30.0	272.6	Нээлттэй
	Нийт дүн	697.7	391.55	432.7	

4.2.10. Жаргалан сумд цэцэрлэгт хүрээлэн байгуулах /3.1 сая төгрөг/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг тухайн сумд шилжүүлсэн байна.

4.2.11. Багш хөгжлийн ордны гадна цэвэр дулааны шугам сүлжээний угсралт /үлдэгдэл санхүүжилт/-ийн төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг 2022 оны 04 дүгээр

сарын 21-ний өдөр харьцуулалтын аргаар 64 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр зарлан "Моденс" ХХК нь 63.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулжээ. Сонгон шалгаруулалтыг зарлахдаа ашиглагч байгууллагын саналыг үндэслээгүй, ажлын тоо хэмжээг дахин нягтлан шалгахгүйгээр Мандал-Голомт ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн техникийн нөхцөлд өгөгдсөний дагуу 110м шугам сүлжээ угсрахаар ажлын тоо хэмжээг тодорхойлсон байна.

Гэвч гүйцэтгэгч компаниас ажлыг гүйцэтгэх явцад бодит ажлын тоо хэмжээ 190м шугам сүлжээ угсрахаар байсны дагуу сонгон шалгаруулалтыг дахин явуулахгүйгээр гэрээнд өөрчлөлт оруулан гэрээний нийт дүнг 107.0 сая төгрөг болгож нэмэгдүүлж байгуулсан байна.

4.2.12. Энэ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсвийг журмын дагуу гүйцэтгээгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагааны төсөвт өртгийг буруу тооцож хэрэглэвэл зохих шалгаруулалтын аргыг хэрэглээгүй, төсөвт өртөг 43.4 сая төгрөгөөр нэмэгдэж төсөвт ачаалал өгөх үндсэн шалтгаан болсон байна.

Тайлант онд хүлээн авсан 3 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 25.8 сая төгрөгийн гүйцэтгэгчид олгоогүй байна.

4.3.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,213.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл арга хэмжээнд 525.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж 814.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Гүйцэтгэлээр тайлант онд 204.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Хүснэгт №5. Төсөл, арга хэмжээний санхүүжилт

№	Төсөл арга хэмжээний нэр	Баталсан санхүүжилт	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл
1	Дулааны станц ДДТ-ын барилгын гадна холбоо дохиоллын шугам сүлжээний зураг төсөл	15.0	6.0	9.0
2	Дулааны станц ДДТ-ын барилгын гадна, цэвэр, ариутгах татуургын шугам сүлжээний зураг төсөл	20.0	13.6	6.4
3	Хантайширын гудамжны явган хүний замыг өргөтгөн шинэчлэхэд шаардлагатай материал худалдан авах	25.0	22.4	2.6
4	Бигэр сумын хорооллын гадна цахилгааны дэд өртөө, шугам сүлжээний ажил	44.3	33.9	10.4
5	Бигэр сумын нутаг дэвсгэрт баригдах 120 айлын орон сууцны өөрчлөлт, холболтын зураг	3.0	3.0	0.0
6	Залуус цэцэрлэгт хүрээлэн, залуус гудамжны усалгааны систем	3.0	3.0	0.0
7	Усны машин нийлүүлэх /Төгрөг сум/	50.0	50.0	0.0
8	Жаргалан сумд цэцэрлэгт хүрээлэн байгуулах	3.1	3.1	0.0
9	Багш хөгжлийн ордны гадна цэвэр дулааны шугам сүлжээний угсралт /үлдэгдэл санхүүжилт/	43.4	36.9	6.5
10	Сумдын 120 айлын орон сууцны зохиогчийн хяналтын зардал	15.0	3.0	12.0
11	Есөнбулаг сумд байрлах Нийтийн номын сангийн зүүн уулзвараас, Солонго	30.0	30.0	0.0




	хорооллын уулзвар хүртэлх 300м автозамын ажил			
	Нийт дүн	251.8	204.9	46.9

- 4.3.2. Дулааны станц ДДТ-ын барилгын гадна холбоо дохиоллын шугам сүлжээний зураг төсөл, Дулааны станц ДДТ-ын барилгын гадна , цэвэр, ариутгах татуургын шугам сүлжээний зураг төсөл, Бигэр сумын хорооллын гадна цахилгааны дэд өртөө, шугам сүлжээний ажлыг тайлант онд хүлээн боловч үлдэгдэл санхүүжилт болох 25.8 сая төгрөгийн гүйцэтгэгчид олгоогүй байна.
- 4.3.3. Харин Хантайширын гудамжны явган хүний замыг өргөтгөн шинэчлэхэд шаардлагатай материал худалдан авах, Багш хөгжлийн ордны гадна цэвэр дулааны шугам сүлжээний угсралт /үлдэгдэл санхүүжилт/ төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 7.8 сая төгрөгийн чанарын баталгаа болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.
- 4.3.4. Сумдын 120 айлын орон сууцны зохиогчийн хяналтын зардал нь ажил дуусаагүй тул олгоогүй байна.
- 4.3.5. Тайлант онд шинээр тусгагдсан 8 төсөл, арга хэмжээнээс 5 нь хэрэгжиж Шарга сумын "Хамтын хүч" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх, Алтай сумын "Баянцагаан" багт үүрэн холбооны сүлжээ тавихад дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээ нь гүйцэтгэгч шалгараагүй гэх үндэслэлээр, Өрх бүрт өсөлт, иргэн бүрт орлого арга хэмжээний хүрээнд шинээр гэр бүл болж байгаа малчин залуу өрхийг малжуулах /50 бог мал/ төсөл, арга хэмжээний санхүүжилтийг буцаан татсан гэх үндэслэлээр хэрэгжээгүй байна.

Төсөл, арга хэмжээг хүлээн авч гэрээг дүгнэж байгаа боловч үр дүнг тодорхойлоогүй байна.

- 4.4.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 402.71 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан байна. Үүнээс:
- Бүрэн хэрэгжсэн 364.7 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын хөрөнгийн дансанд тусгасан байна.
 - Бүрэн хэрэгжсэн 38.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй.
 - Тайлант онд хэрэгжих 411.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 56.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээ дуусаагүй байна.
- 4.4.2. Хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээ нь анх төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. Үүнд:
- Хантайширын гудамжны явган хүний замыг өргөтгөн шинэчлэхэд шаардлагатай материал худалдан авах төсөл, арга хэмжээний хувьд 100,000.0 ширхэг хавтанг байршуулахаар төлөвлөсөн ч эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн хойд талын 8,000 ширхэг хавтанг байршуулсан байна.



/зураг №33/
Хантайширын гудамжинд
байршуулсан байдал



/зураг №34/
Гуравдугаар цэцэрлэгийн хойд талд
байршуулсан байдал

- Залуус цэцэрлэгт хүрээлэн, залуус гудамжны усалгааны систем төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын тогтоолд тусгаснаас өөр байршилд буюу Усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн хашаа, Солонго хорооллын “Ногоон төгөл”-д тус тус салган гүйцэтгэжээ.



/зураг №35/
Усан спорт чийрэгжүүлэлтийн
төвийн хашаанд байршуулсан
байдал



/зураг №36/
Солонго хорооллын Ногоон төгөлд
байршуулсан байдал



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Жинет баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093
Утас/Факс: 7048-4042 Цахим шуудан: info@govi-altai.gov.mn

2024. 06. 03 № 11720
танай 2024. 05. 24 -ны № 279 -т

Хариу хүргүүлэх тухай

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн жагсаалтыг хүлээн авч танилцаад дараах тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдалтай холбоотой тайлбар, саналыг аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/401 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2. Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлтэй танилцаж, тухайн аудитын явцад илэрсэн зөрчил дутагдал нь ихэвчлэн төлөвлөх, батлуулах шатны үйл ажиллагаатай холбоотой байгаа тул шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнах хугацааг дараа оны төлөвлөлтийн хугацаанаас хойш байхаар, мөн жагсаалтын 4, 5-д заасан зөрчлийн албан шаардлага гэсэн шийдвэрийг зөвлөмж болгон өөрчилж өгөхийг хүсье.

Цаашид “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засаж залруулж ажиллах болно.

Хавсралт 3. хуудастай.



О.АМГАЛАНБААТАР

8200040246



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093
Утас/Факс: 7048-4042 Цахим шуудан: info@govi-altai.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

2024.03.29 № 1/401

тантай _____ -ны № _____ -т

Тайлбар гаргах тухай

Танай байгууллагаас "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн жагсаалтыг хүлээн авч танилцаад дараах тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын комиссын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн ГАА-КД-20/2023 дугаартай актаар хүлээн авсан "Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /" төсөл арга хэмжээг орон нутгийн өмчид бүртгээгүй байгаа шалтгаан нь уг ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, Улсын комисс ашиглалтад хүлээн авсан хэдий ч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалтад заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны үндсэн дээр орон нутгийн өмчид бүртгэх ёстой бөгөөд одоогийн байдлаар шийдвэр ирээгүй, орон нутгаас шалтгаалсан зүйл байхгүй тул данс бүртгэлд тусгах боломжгүй юм.

2. Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2 дугаар сургууль/-ийн ариун цэврийн өрөөний бохирын шугам хөлдсөн гэх шалтгаанаар тус өрөө ашиглалтгүй, Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/-ийн цэвэр усны шугам хөлдсөн, агааржуулалт муутай, Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар сургууль/-ийн дотор камер ажилладаггүй, усны хаялага унасан, дээврээс ус гойжсон байгаа зэрэг нөхцөл аудитын явцад илэрсэн байна. Гэвч ажлыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулснаас хойш ашиглагч байгууллагуудаас захиалагч болон захиалагчийн хяналт тавьсан байгууллагад ямар нэгэн гомдол, санал ирүүлээгүй бөгөөд Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулиас 2023 оны 10 сарын 26-ны өдрийн 105, 2 дугаар сургуулиас 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 91, 3 дугаар сургуулиас 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 99 дугаар албан бичгүүдээр ямар нэгэн доголдол саад, зөрчилгүйгээр ажиллаж байгаагаа нотолж байгаа тул уг асуудлыг зөрчлөөр хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Иймд "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн жагсаалтад заасан дээрх 2 зөрчлийг зөрчлөөс хасуулах саналтай байгаа бөгөөд Үндэсний аудитын газарт хүргүүлж буй зөвлөмж, жагсаалтын 4 дугаарт бичигдсэн зөрчлийг засаж залруулж ажиллах болно.

Хавсралт 4 хуудастай.



О.АМГАЛАНБААТАР

8209340156



САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР:

Саналын дугаар	Хариу тайлбар	Тайлбар
1	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”,-ыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.7-д “Улсын төсөв, хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн төрийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээр хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасан. Гэвч тус төсөл” арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн КД-20/2023 дугаар актаар хүлээн авсан боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй байгаа тул хөрөнгө эзэнгүйдэх, хадгалалт хамгаалалтгүй болох, чанар байдал муудах эрсдэл үүсэхээр байна.	Тайлбарыг хүлээн авах боломжгүй.
2	Аудитаар захиалагч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудын холбогдох албан тушаалтан нартай хамтран төсөл, арга хэмжээний хэрэгжилт, явцтай танилцсан. Хэдийгээр өмнө нь ашиглагч байгууллагуудаас гомдол, санал гаргаагүй байх боловч аудитын явцад дээр дурдсан нөхцөл байдлууд тогтоогдсон болно.	Тайлбарыг хүлээн авах боломжгүй.
3	Тухайн аудитын явцад илэрсэн зөрчил дутагдал нь ихэвчлэн төлөвлөх, батлуулах шатны үйл ажиллагаатай холбоотой байгаа тул шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнах хугацааг дараа оны төлөвлөлтийн хугацаанаас хойш байхаар, мөн жагсаалтын 4, 5-д заасан зөрчлийн албан шаардлага гэсэн шийдвэрийг зөвлөмж болгон өөрчилж өгөхийг хүсье.	Шийдвэрийн хэрэгжилтийн хугацааны саналыг хүлээн авч албан шаардлагын хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр ирүүлэхээр тусгав. Жагсаалтад тусгагдсан 5 дахь зөрчлийг зөвлөмжөөр хүргүүлэхээр тусгав.



ДҮГНЭЛТ:

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

А.Улсын төсвийн хөрөнгө оруулалт

1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүйгээс хэрэгцээ шаардлагыг хангахгүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.
2. Зохиогч болон техникийн хяналтыг эрх бүхий этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа боловч улсын комисс хүлээн авсан барилга байгууламж, их засвар чанар байдал муутай байгаа нь хяналт үр нөлөө багатай, хангалтгүй байна.
3. Гүйцэтгэгч нь төсөл, арга хэмжээг чанар байдал муутай хэрэгжүүлсэн байхад дараагийн шатны арга хэмжээг аваагүй байна.
4. Улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглах боломжгүй барилга байгууламжид их засвар хийж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.
5. Хүлээн авсан байгууламжийг данс бүртгэлд тусгаагүй нь хөрөнгө эзэнгүйдэх, чанар байдал муудах үр дагаврыг үүсгэхээр байна.
6. Шилэн дансны цахим системд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.

Б.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

1. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн баримт бичигт нийцүүлэн төлөвлөхгүй байна.
2. Төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын бус шинжтэй, урсгалд зардалд зарцуулахаар төлөвлөж байна.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төсөв, техникийн нөхцөлгүй, цаашид гарах урсгал зардал болон үр ашгийн тооцоо хийгээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байна.
4. Тайлант онд хүлээн авсан төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг гүйцэтгэгчид олгоогүй байна.
5. Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.
6. Аймгийн ИТХ-ын тогтоолд өөрчлөлт ороогүй байхад тусгасан арга хэмжээг шийдвэргүйгээр байршлыг өөрчилж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

ШИЙДВЭР:

Аудитын дүгнэлтэд үндэслэн Үндэсний аудитын газарт нэгдсэн тайланд тусгуулах 1 санал, аймгийн ИТХ-д 1 зөвлөмж, аймгийн Засаг даргад 4 зөвлөмж, 996.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах 2 албан шаардлага, тус тус хүргүүлээ.

Үндэсний аудитын газарт уламжлах санал:

- Улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглах боломжгүй барилга байгууламжид их засвар хийхээр хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээг тусгахгүй байх талаар нэгдсэн тайланд тусгах.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх зөвлөмж:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус шинжтэй, урсгал зардал, ТЭЗҮ, зураг төсөв, техникийн нөхцөлгүй, хууль заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг батлахгүй байх.



Аймгийн Засаг даргад хүргүүлэх зөвлөмж:

- Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт нийцээгүй, ТЭЗҮ, зураг төсөв, техникийн нөхцөлгүй, цаашид гарах урсгал зардал болон үр ашгийн тооцоо хийгээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхгүй байх.
- Аймгийн ИТХ-аас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор баталсан тогтоолын биелэлтийг хяналтад авч, хэрэгжилтийг тайлагнах.
- Төсөл, арга хэмжээ бүрээр хувийн хэрэг үүсгэн санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд олгон гэрээг тухай бүр дүгнэж ажиллах.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг иргэд олон нийтэд танилцах боломжтой байхаар ил тод, үнэн зөв мэдээлэх.

Аймгийн Засаг даргад өгөх албан шаардлага:

- Тайлант болон өмнөх онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад хяналт хийж шаардлага хангаагүй ажлыг дахин гүйцэтгүүлэх арга хэмжээг авч,
- Нягтлан бодох бүртгэлд 394.9 сая төгрөгийн хөрөнгийг тусгаагүй зөрчлийг арилгах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР